



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/654

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад оруулах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8-р багт баригдсан Төрийн банкны барилгыг хүлээж авах байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Энхжаргал	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	Х.Даваасүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
	Ж.Жавзанпагма	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
	Х.Тайванбаяр	(Мөрөн сумын Засаг дарга)
	С.Анхбаяр	(Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын байцаагч, ахмад)
	Д.Мягмарсүрэн	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
	Д.Аюушжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Гал-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
	Г.Даваадорж	(“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий инженер)
	Д.Сүхээ	(“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн Ерөнхий инженер)
	Ш.Нямханд	(Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн ерөнхий инженер)

6712011523



Г.Дэлгэрнасан (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн Хүртээмж нийгмийн оролцооны мэргэжилтэн)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн, Архитектор )

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Батцэнгэл ("Тоонот констракшн" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

А.Бат-Эрдэнэ ("Монничинкон трейд" ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Л.Дашцэрэн (Төрийн банкны Хөвсгөл салбарын захирал )

М.Өнөрцэцэг (Төрийн банкны аж ахуй, аюулгүй байдлын газрын Барилгын инженер )

Б.Хажидмаа (Төрийн банкны Хөвсгөл салбарын ерөнхий нягтлан бодогч )

Ч.Энх-Амгалан (Төрийн банкны Хөвсгөл салбарын харилцааны ахлах менежер )

Ш.Хүрэлбаатар (Төрийн банкны Хөвсгөл салбарын тооцооны төв хариуцсан менежер )

М.Бат-Эрдэнэ (Төрийн банкны Хөвсгөл салбарын тооцооны төв хариуцсан менежер )

Г.Жамбалгарав (Төрийн банкны Хөвсгөл салбарын тооцооны төв хариуцсан менежер )

С.Батбаяр (Төрийн банкны Хөвсгөл салбарын мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн )

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот -байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

